

ЭРДЭМ  
ШИНЖИЛГЭЭНИЙ  
ХУРАЛ

**МОНГОЛ-АМЕРИКИЙН  
ЭРДЭМТДИЙН III УУЛЗАЛТ  
ЮУ ХАРУУЛАВ**

Монгол, америкийн эрдэмтдийн Ш уулзалт АНУ-ын Сан-Франциско хотноо 1990 оны 5 дугаар сарын 24-26-нд болж, монголын төлөөлөгчдийн бүрэлдэхүнд ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэнгийн захирал Ш. Сандаг, ШУА-ийн дэд ерөнхийлөгч, философи, социологийн хүрээлэнгийн захирал, ШУА-ийн сурвалжлагч гишүүн С. Норовсамбуу, ДДСХ-ийн монгол-Хятадын харилцааны тасгийн эрхлэгч доктор Ч. Далай, япон судлалын тасгийн эрхлэгч Д. Дүнгэр-Яйчил, Худалдаа хамтын ажиллагааны яамны зах зээл судлалын институтын захирал, дэд эрдэмтэн М. Энхсайхан, НҮБ-д суугаа монголын төлөөлөгчдийн газрын зөвлөх Б. Должинцэрэн, МЭТНБХ-ны ажилтан Ч. Ганболд (төлөөлөгчийн нарийн бичгийн дарга) нар оролцжээ.

Монголын төлөөлөгчдийн илтгэл, хэлсэн үгэнд өөрчлөн байгуулалт явагдаж буй БНМАУ-ын гадаад бодлого, олон улсын үйл ажиллагааны шинэлэг чиглэл, үзэл санаа тусч, дэлхий дахин, түүний дотор Ази, Номхон далайн бүс нутгийн тулгамдсан асуудлуудыг шинэ сэтгэлгээний үүднээс үнэнхүү бүтээлчээр авч үзэж дүгнэсэн явдал Монгол-америкийн уулзалт 3-ын нэг онцлог шинж тэмдэг мөн. Нөгөө талаар, америкийн эрдэмтэд ч олон улсын харилцаанд шинэ байр сууринаас хандаж, аливаа асуудлуудыг бодитойгоор тайлбарлах ойлгох, дүгнэхийг хичээсэн тал илт байлаа.

БНМАУ-ын ШУА-ийн Дорнодахины судлалын хүрээлэн, АНУ-ын Зүүн Азийн судлалын хүрээлэнгийн шугамаар хоёр жил тутам, нэг удаа зохиогддог монгол, америкийн эрдэмтдийн уулзалт уламжлал боллоо. Тийнхүү манай өөрчлөгдөн шинэчлэгдэж буй дэлхий ертөнц, олон улсын харилцаа, Ази, Номхон далайн бүс нутгийн улс төрийн уур амьсгал, аюулгүй байдлын олон тулгамдсан асуудлаар хоёр талын эрдэмтэд ил тод, нөхөрсөг байдалд санаа бодлоо солилцож, өргөн маргаан явуулж, харилцан байр сууриа тодорхойлдог байнгын индэртэй боллоо. Үүнд Зүүн Азийн судлалын америкийн хүрээлэнгийн захирал, олон улсын харилцааны нэрт эрдэмтэн, профессор Роберто Скалапино ихээхэн санаачилга гаргаж их ч үүрэг гүйцэтгэсэн ажээ.

Монгол, америкийн эрдэмтдийн Ш уулзалт-бага хурал хэлэлцсэн асуудал, бүрэлдэхүүний хувьд, бас чөлөөтэйгөөр санал солилцсоны хувьд урьдах уулзалтуудаас огт өөр боллоо.

Улаанбаатарт 1988 оны хавар болсон монгол, америкийн эрдэмтдийн П уулзалтаас хойш хоёр жил өнгөрч, дэлхийн нүүр царай ч ихээхэн өөрчлөгдлөө. Өөрчлөн байгуулалтын үзэл санаа зөвхөн социалист орнууд тэдгээрийн нам, төрийн систем, гадаад, дотоод бодлогод нөлөөлж, зарчмын өөрчлөлт гаргаж байгаагаар үл барам, дэлхий даяар түгж, олон улсын харилцаа, улс дундын уур амьсгалд нааштай хандлага зонхилоход түлхэц өгчээ.

Өнөө үед сөргөлдөөн мөргөлдөөнөөс харилцан ойлголцох, итгэлцэхэд хаа сайгүй шилжиж байна. Аль нэг улс нөгөөг «дайсан» гэж хардан сэрдэж, хажиглан хөндийрөх бус, харин харилцан ойлгох, хамтран ажиллахыг эгээрч, эрх ашгаа зохицуулах, нийт хүн төрөлхтний эрх ашгийг урьдал болгох, цөмийн дайны аюулыг аажмаар намжааж бүр мөсөн зайлуулах, улс түмний нийтийн амгалан тайван байдлыг са-

хин бэхжүүлэх, эх дэлхий орчноо хайрлан хамгаалах зэрэг зорилт эн тэргүүнд тавигдаж байна.

Олон улсын хамтын ажиллагаа, эв найрамдлыг бэхжүүлэх, дайны аюулыг дарж, энх амгаланг сахих нь улс улсын эрх барих төр, намын зүтгэлтнүүдийн үйл ажиллагааны шалгуур мөн.

Харилцан ойлгох, итгэх уур амьсгалыг бий болгоход эрдэмтдийн үүрэг багагүй билээ.

Сан-Францискод болсон Ш уулзалтаар хоёр орны эрдэмтэд чухал асуудлууд хэлэлцсэний дотор Ази, Номхон далайн бүс нутгийн улс төр, эдийн засгийн зангилаа асуудлууд, өөрчлөлт шинэчлэл, түүний үр дагавар, нөлөө, Зүүн хойд Азийн одоогийн улс төрийн байдал, их гүрнүүдийн байр суурь, Ази, Номхон далайн бүсийн аюулгүй байдал зэрэг тодорхой сэдвүүдээр монгол, америкийн эрдэмтэд санал бодлоо илэн далангүй солилцлоо.

Профессор Р. Скалапино «Улс төр, эдийн засгийн талаар өөрчлөгдөн буй Ази дахин ба олон улсын дэг журамд түүний эзлэх байр суурь» гэсэн илтгэл тавив. Азийн орнуудын дотоод байдал, хоорондын харилцаа, бүс нутгийн олон улсын харилцааны байдлыг тэр тодорхойлов. Жижиг ба дунд зэргийн улсууд бүс болон дэлхийн олон улсын амьдралд үүрэг, хариуцлага нь өндөржиж байгаа тухай тэр яриу.

ЗХУ-д Горбачевын хувьсгал болон Дорнод Европыг хамарсан ихээхэн өөрчлөлт гарч, коммунист нам бусад хүчинтэй уралдахаас өөр аргагүй болов. ЗХУ-тай стратеги, эдийн засаг, соёлын талаар нягт холбоотой байгаагийн хувьд Монголд Горбачевын арга хэмжээ эрт, орой алин боловч хүчтэй тусах нь ойлгомжтой байлаа. Монгол дахь шинэчлэл улс төр, эдийн засгийн яг ямар төлөвтэй болох нь тодорхойгүй, гэвч сая тэнд дээд удирдлагад гарсан өөрчлөлт улс төрийн салхи хүчтэй нөлөө үзүүлсний баталгаа мөн гэх зэргээр түүний илтгэлд олон чухал санал орлоо.

Монголын талаас миний бие «Ази, Номхон далайн бүс нутгийн улс төрийн зангилаа асуудлууд» илтгэл тавив.

Өөрчлөн байгуулалт, ил тод байдал, ардчилал олон улсын амьдралд гүнээ нөлөөлж, аливаа тулгамдсан асуудалд хүлээцтэй, бодитой байр суурь, шинэ сэтгэлгээний үүднээс хандах хандлагыг хүчтэй болгож байна гэдгийг дурдаад илрэл нь гэвэл, ЗХУ, АНУ-ын тэргүүн М. С. Горбачев, Ж. Буш нарын Мальт, Вашингтоны дээд хэмжээний уулзалт мөн гэдгийг цохож яриу.

Цөмийн зэвсэгт хамгийн хүчирхэг хоёр гүрний харилцаа сайжирч, харилцан ойлгох явдал лавшрах нь бүх дэлхий болон бүс нутгийн улс төрийн уур амьсгал эрүүлжихэд онцгой нөлөөтэй нь маргаангүй юм.

Ази, Номхон далайн бүс нутгийн хувьд ч улс төрийн уур амьсгал сөргөлдөөн мөргөлдөөнөөс харилцан ойлголцох, итгэлцэх, хамтран ажиллах тийшээ хандаж байна. Зүүн хойд Азид гарсан томоохон алхам гэвэл, үүний түрүүн М. С. Горбачев БНХАУ-д айлчлан дээд хэмжээний уулзалт хийж хоёр орны харилцаа хэвийн болон сайжрах эхэн тавигдаж, улмаар БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн дарга Ли Пэн ЗХУ-д айлчилж хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлсэн, саявтар БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга П. Очирбат өмнөд хөрш БНХАУ-д албан ёсны дээд хэмжээний айлчлал хийсэн, тэрчлэн манай нам, төрийн тэргүүн ЗХУ-д айлчилсан зэрэг олон улсын чухал ач холбогдолтой үйл явдлуудыг хэлж болно.

Ази, Номхон далайн бүс нутагт улсуудын хооронд харилцан итгэх уур амьсгал тогтооход чиглэгдсэн санал санаачилгууд бишгүйдээ гарч байна, гагцхүү тэдгээрийг хэрэгжүүлэх явдал чухал болж байна.

Бүгд Найрамдах Солонгос Улсын ерөнхийлөгч Ро Дэ У Зүүн Хойд Азийн 6 орон, тухайлбал, ЗХУ, БНХАУ, АНУ, Япон, Умард, Өмнөд Солонгосын дээд хэмжээний уулзалтын тухай санал тавьсан нь БНМАУ-аас Зүүн хойд Азийн найман орны, тухайлбал, БНМАУ, АНУ, Япон, БНХАУ, ЗХУ, Канад, Умард, Өмнөд Солонгосын дээд хэмжээний уулзалт зохион байгуулах талаар дэвшүүлсэн саналтай ямар нэг талаар дүйж байгаа юм. Тэрчлэн Ким Ир Сений дэвшүүлсэн таван зүйлт санал зэрэг Солонгосын хойгт энх амгалан байдлыг хангах талаархи арга хэмжээнүүдийг амьдралд хэрэгжүүлэх нь энэ бүс нутаг төдийгүй, дэлхий дахины аюулгүй байдлыг бэхжүүлэхэд эрхэм сайн тус болно.

Үүнтэй холбогдуулж Дорнодахины судлалын хүрээлэн Гадаад явдлын яамтай хамтран манай саналыг хэрэгжүүлэх алхам хийх үүднээс энэ аравдугаар сарын 2-4-нд Зүүн хойд Азийн найман орны эрдэмтэн, мэргэжилтний олон улсын уулзалт зохион байгуулахаар төлөвлөж байгаа нь энэ чигт явуулж буй үйл ажиллагаанд нэмэр хандив болох байх аа.

Өнөөдөр олон намтай болж парламентын систем тогтож, нээлттэй эдийн засгийн бодлого эхлэн явуулж буй Монголыг Япон, Өмнөд Солонгос, Тайланд, Сингапур мэт улсууд ихэд сонирхон улс төрийн талаар харилцан ойлгож, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлж байгаа нөхцөлд америкийн пүүсүүд арай л хоцорч байна уу даа гэдгийг би илтгэлдээ дурдаж, манай нийслэл Улаанбаатарт одоогоос 70-аад жилийн тэртээд америкийн пүүсүүд, худалдаа-үйлдвэрийн хэн ирж байрлаж байсан «Американ дэнж» гэж газар буй нь нэрнээс цаашгүй болсныг одоо цаг өөр болж, сайхан бололцоо нээгдэж байгаа тул эрхиш бодож үзүүштэйг ч цохож хэлсэн юм.

Америкийн талаас Дорнод Азийн судлалын хүрээлэнгийн захирал Р. Скалапиногоос гадна Вашингтоноос Жон Гопкинсын их сургуулийн олон улсын судлалын газрын профессор Эвелин Колберт авхай, Жоржи муж улсын Атлант хотын технологийн институтийн олон улсын Атлант хотын технологийн институтийн олон улсын стратеги, технологи, улс төр, судлалын төвийн профессор Жон Эндикот, Гонконг дахь Номхон далайн Траст Секьюрити банкны төлөөлөгч, бүс нутгийн стратеги судлаач Уильям Овер Холт, Калифорнийн их сургуулийн Сан Диего дахь олон улсын харилцаа, Номхон далайн судлалын төвийн эрдэмтэн Бэрри Нортон, мөн Сан-Диего дахь улс төрийн ухааны судлалын төвийн эрдэмтэн Грегори Нобле нар үг хэлсэн юм.

Олон улсын харилцаа, Ази, Номхон далайн бүс нутгийн тулгамдсан асуудлууд хэлэлцэхэд монгол, америкийн эрдэмтдийн баримталж байгаа байр суурьд урьд өмнөх уулзалтуудыг бодвол нийлэх буюу ойр дөт тал нь нэлээд тэлж, тохирохгүй, зөрүүтэй тал нь хумигдаж багассан байна.

Үүний учир бол улирах цагийн эрхээр, өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээний дагуу манай дэлхийн тавцнаа өөрчлөгдөн ахуй улс төрийн бодлогын тусгал мөн гэж үзвэл болно. Монгол, америкийн талын аль аль нь улс төр, шинжлэх ухааны түвшин дээр аливаа асуудалд бодитой хандах болж байгаагийн тэмдэг байх аа. Тухайлбал, ЗХУ, АНУ-ын харилцаа сайжирч, харилцан ойлголцох түвшин дээшилж дээд хэмжээний уулзалтууд нь зохих үр дүнгээ өгч, дэлхий даяар болон

Ази, Номхон далайн бүс нутагт улс төрийн уур амьсгал эрүүлжиж, эдийн засгийн хамтын ажиллагаа өрнөж байгаа тухай олон асуудлаар санал нэг байна. Өөрчлөн байгуулалт, шинэ сэтгэлгээ, олон улсын харилцаанд нэвтэрч, аливаа асуудалд бодитой, хүлээцтэй хандах нь чухал тухайд санал тохирч байна. Социалист орнуудад явагдаж байгаа өөрчлөн байгуулалт дэлхий дахины ач холбогдолтой болох талаар бодол нэг байна. Харин бид Сталины загварын социализм нуран унаж, оронд нь хүнлэг ардчилсан нийгмийг босгож байгаа тухай ярихад, америкийн тал ер нь социализм үгүй болж байгаа гэсэн нь санал зөрүүтэй санагдлаа. Таваар мөнгөний харилцаа, чөлөөт зах зээлийг хөгжүүлэх нь социализмыг үгүйсгэх ёстой гэж америкийн тал үзэж байхад бид ардчилсан социализмын хүрээнд болно гэсэн баримтлалтай байв.

Солонгосын хойгоос америкийн цэрэг, цөмийн зэвсэг гаргах, ер нь Ази, Номхон далайн бүс нутагт харилцан ойлголцох, итгэлцэх уур амьсгал бий болгох нь чухал гэж хоёр тал үзэхийн зэрэгцээ тийм цэгт хүрэх арга замын талаар санал нэлээд өөр өөр байх юм.

Хамгийн гол нь одоо санал бодол зөрүүтэй байгаад бус харин аливаа асуудлаар хоёр талын байр суурийг хэрхэн ойртуулах вэ? гэдэгт байна. Үүний тулд санал бодлоо илэн далангүй солилцож, чөлөөтэй маргаан явуулж байх нь чухал юм.

Монгол, америкийн эрдэмтдийн байнгын уулзалтын улс төрийн ач холбогдол нь БНМАУ-ын олон улсын харилцааны мэргэжилтэй эрдэмтэд АНУ-ын эрдэмтэдтэй учирч, хэлхээ холбоо тогтоон, харилцан айлчилж, ном хаялцаж, санал бодлоо солилцож байгаад оршино.

Вашингтонд байхад төрийн департаментад биднийг хүлээн авч уулзсан. Уулзалтад тус газрын Дорнод, Ази, Номхон далайн судлалын газрын захирал Томас Фингар, гадаад бодлого судлаач Дебора Кинслэнд, мөн манайд шинээр томилогдсон элчин сайд И. Лэйк нар оролцож, АНУ-ын төрийн департаментаас Ази, Номхон далайн бүс нутагт явуулж буй гадаад бодлогын чиг шугамтай товч танилцуулж, бид ч өөрийн орны гадаад бодлогын талаар ярих.

Мөн Азийн фондод очиход түүний ерөнхийлөгч Уильям Фуллер хүлээн авч, байгууллагаа товч танилцуулж, тэнд болсон ярилцлагад дэд ерөнхийлөгч Аллен Чоат, Зүүн хойд Азийг судлах газрын захирал, философийн ухааны доктор Шелдон Северинханс нар оролцлоо.

ЮСИА буюу америкийн мэдээллийн агентлагт Дорнод, Ази, Номхон далайн судлалын газрын захирал Давид Хичкок уулзаж, байгууллагынхаа ажил байдалтай танилцууллаа.

Вашингтонд Брукингийн институт дээр уулзалт болж, профессор Харри Хардинг хүлээн авч тэндэхийн эрдэмтэдтэй олон улсын өнөөгийн харилцаа, Ази, Номхон далайн бүс нутгийн асуудлаар ярилцлага зохиов. Ярилцлагад вашингтон дахь америкийн овсгоо санаачилгын институтийн олон нийтийн бодлого судлах, газрын хятад судлалын программын удирдагч Томас Робинсон, Брукингийн институтийн ахлах эрдэмтэн Томас Мкногер, тэнд гадаад бодлого судлах программаар ажиллаж буй Сеулийн их сургуулийн эдийн засгийн факультетийн эрдэмтэн Юй Гак Хван, Сеулийн үндэсний их сургуулийн хүн судлалын газрын философийн факультетийн профессор Ерсу Ким зэрэг хүмүүс оролцсон.

Монгол, америкийн эрдэмтдийн шуулзалтад манай төлөөлөгчийн зарим нь илтгэл, хэлэх үгээ англиар, зарим нь монголоор тавьсан. Гадаадад олон улсын хурал уулзалтад хэрэв олон улсын хэл заавал шаардагдахгүй ахул монголоороо үг хэлж байх нь үндэсний бахархал юм.

Манай уулзалтад Монголд огт ирээгүй америкийн эрдэмтэд монгол хэлийг анх сонсч суух нь их тааламжтай байх шиг байсан. Тэд ч танай хэл сонин сайхан юм гэж ярьж байсан.

Манай төлөөлөгчид хурлын бус цагаар юм уу, Вашингтонд төрийн департамент, америкийн мэдээллийн төв —ЮСИА, Азийн фонд зэрэг газар эрдэмтэдтэй англи, хятад, Японоор ярилцаж байсан.

Монгол, америкийн эрдэмтдийн Ш уулзалтыг зохион байгуулах үүрэгтэй байсан Бэркли дэх Дорнод Азийн хүрээлэнгийн профессор Харли Кэндал гуай, манай төлөөлөгчдийн зохицуулагч, МЭТНБХ-ны гүйцэтгэх хорооны ажилтан Ч. Ганболд нар хурлын ажиллагааг өндөр хэмжээнд сайн зохион байгуулахад их тус хийснийг тэмдэглэе.

**Ш. САНДАГ**